


“Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын  
Захирлын 20.00-оны 01 дугаар сарын 13-ний өдрийн  
А/01 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг: Ерөнхий зүйл

1.1 Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааны зорилго нь хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, ажлын зүй зохистой орчинг бүрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах, үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулахад оршино.

1.2 Зөвлөл нь Монгол улсын “Хөдөлмөрийн тухай хууль”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” болон энэхүү журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

Хоёр: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн зохион байгуулалт

2.1 Зөвлөл нь 11 хүний гишүүнтэй байна. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, ажилчдын төлөөлөлтэй байх бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөл нь үйл ажиллагааныхаа тайланг байгууллагын хамт олонд улирал бүр тайлагнана.

2.2 Зөвлөл нь Монгол улсын “Хөдөлмөрийн тухай хууль”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” болон олон улсын, дотоодын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр гарсан дүрэм, журам холбогдох хууль эрх зүйн бичиг баримтуудыг удирдлага болгон ажиллана.

2.3 Зөвлөл нь өөрийн чиг үүрэгтэй холбогдуулан зөвлөмж гаргана. Зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг алба, хэлтэс, цех, нэгжүүдийн удирлагууд биелүүлэх үүрэгтэй.

Гурав: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн  
зөвлөлийн гүйцэтгэх үүрэг, эрх

3.1. Зөвлөлийн үүрэг

3.1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллах

3.1.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар санал боловсруулж ажил олгогч, ажилтны төлөөлөл нарт хүргүүлэх

3.1.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн системийн хүрээнд нийт ажилтнуудад мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, үйл ажиллагааг сайжруулах санал, зөвлөмж гаргах

3.1.4. Ажлын байр, хөдөлмөрийн нөхцөлд хөдөлмөрийн аюулгүй байдлын 3 шатны үзлэг хийж гарсан үр дүнг ажил олгогч болон ажилтануудад мэдээлж хууль, дүрэм стандартын шаардлагад нийцүүлэх чиглэлээр зөвлөмж хүргүүлэх

3.1.5. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн хангалт, хэрэглээ, ажлын байр, ариун цэвэр, эрүүл ахуйн болон эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал, ажилтны хоолны чанарт үзлэг хийх, үр дүнг хамт олонд танилцуулах, мэдээлэх

3.1.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажилтны гаргасан санал, хүсэлтийг шийдвэрлүүлэх талаар ажил олгогчид зөвлөмж хүргүүлэх

3.2. Зөвлөлийн эрх

3.2.1 Ажлын байр, хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийх ажилд ажил хариуцсан албан тушаалтан, мэргэжлийн ажилтнуудыг татан оролцуулах,

3.2.2. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлого, үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн талаар мэдээлэл гаргуулан авах

3.2.3. Хэлтэс, алба, цех нэгжийн удирдлагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байрны нөхцлийг сайжруулах, гарч болзошгүй осол, эндэгдэл, өвчлөлөөс сэргийлэх арга хэмжээ авах талаар шаардлага тавих

3.2.4. Байгууллагын захиргаанд хөдөлмөрийн эрүүл, аюулгүй нөхцлийг бий болгох сайжруулахад идэвхи санаачилгатай оролцсон хэлтэс, алба, цех, хэсэг, хувь хүнийг хамт олны хурлаар урамшуулах санал оруулах

3.2.5. Шаардлагатай тохиолдолд аюулгүй ажиллагааны талаар гарсан хууль, тогтоомж, дүрэм, журам илт зөрчигдсөн ажлын байрыг түр хугацаагаар

хаах, үйл ажиллагааг нь зогсоох талаар холбогдох дээд шатны удирдлагуудад мэдэгдэх

#### Дөрөв: Хариуцлага

4.1. Зөвлөлийн гишүүд нь Монгол улсын “Хөдөлмөрийн тухай хууль”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр гарсан дүрэм, журмууд бусад хууль эрх зүйн актуудыг ханган ажиллаагүй тохиолдолд хариуцлага хүлээнэ.

4.2. Монгол улсын “Төрийн албаны тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”-д заасан хариуцлага хүлээлгэнэ.

4.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар ажил олгогч, ажилтан болон хөдөлмөр эрхэлж буй этгээдийн хооронд үүссэн маргааныг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.